

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯРЫН ЯПОН УЛСАД ХИЙСЭН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛЫН ТУХАЙ

Ж. Уянга*

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр гэргийн хамт 2001 оны 2-р сарын 13-18-ны өдрүүдэд Япон улсын Засгийн газрын урилгаар албан ёсны айлчлал тус улсад хийсэн юм.

Энэ бол Ерөнхий сайд Н.Энхбаярын гадаадад хийж буй анхны албан ёсны айлчлал байлаа. Үүнийгээ ч Ерөнхий сайд Японы Үндэсний мэдээллийн төвд хийсэн хэвлэлийн бага хурал дээр “Монгол улсын Ерөнхий сайдын Япон улсад хийж буй анхны айлчлал энэ юм” гэж онцлон хэлсэн юм. Энэ удаагийн айлчлалаар Япон улстай тогтоосон иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөтгөн хөгжүүлэх, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагаа, гадаад харилцааны хүрээнд дэмжиж ирсэн Япон улсын бодлого, үйл ажиллагааг бататгах, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхийг зорьжээ.

Монгол улсын ерөнхий сайд Н.Энхбаяр гэргийн хамт Япон улсын Цог Жавхлант Эзэн Хаан Акихитод бараалхаж, Япон улсын ерөнхий сайд Ё.Мори болон Японы парламентын зөвлөхүүдийн танхимын дарга Иноүэ Ютаката ба Японы парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Ватанүки Тамисүхэ нартай уулзжээ. Японы парламентын удирдлагууд хоёр орны харилцаа, түүний дотор парламент хоорондын харилцааг өргөжүүлэх эрмэлзлэлтэй байгаагаа мэдэгджээ.

Монгол-Японы дипломат харилцаан дахь нэгэн чухал алхам болсон үйл явдал бол ерөнхий сайд Н.Энхбаяр ерөнхий сайд Ё.Моритой уулзаж хэлэлцээ хийсэн явдал юм. Ерөнхий сайд Н.Энхбаяр Монгол улсад ардчилал, шинэчлэл бодит биеллээ олсныг тэмдэглээд шинэ Засгийн газар түүнийг цаашид ч найдвартай амжилтад хүргэхийн төлөө байгаагаа мэдэгджээ. Ерөнхий сайд Ё.Мори хоёр орны харилцаа сүүлийн жилүүдэд ардчилал, эрх чөлөө, хүний үндсэн эрх гэсэн нэгдмэл үнэт зүйлст тулгуурлан бэхжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэхийн хамт Монголын өөрчлөлт шинэчлэлтийг дэмжих Япон улсын Засгийн газрын бодлого өөрчлөгдөхгүй гэдгийг мэдэгджээ. Ерөнхий сайд нар харилцан

* Ж.Уянга - Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх замаар хоёр орны иж бүрэн түншлэлийн харилцааг улам батжуулахын төлөө цаашид ч хүчин чармайхаа нотложээ. Ерөнхий сайд Н.Энхбаяр Япон улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийг Монгол орны эдийн засгийг тогтворжуулах, дэд бүтцийг бэхжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг сэргээж экспортын нөөцийг нэмэгдүүлэх, хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчныг хамгаалах, мэдээллийн технологи, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, боловсон хүчин бэлтгэх зэрэгт түлхүү чиглүүлж зээл, тусламжийн хэмжээг өнөөгийн төвшнөөс бууруулахгүй байхыг хүсчээ. Мөн цаашид хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэхэд чухал шаардлагатай баримт бичгүүд тухайлбал, давхар татвараас чөлөөлөх гэрээ байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэх, Японд сургах оюутнууд, мэргэжил дээшлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, залуучуудын солилцоог өргөжүүлэх, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд бэлтгэх зэрэг саналуудыг дэвшүүлжээ.

Ерөнхий сайд Ё.Мори:

1. Монгол оронд жил дараалан цас зудын хохирол учирч буйд сэтгэл зовниж буйгаа илэрхийлээд, зудын хор хохирлыг арилгахад зориулж өмнө олгосон 10 сая америк доллартай тэнцэх буцалтгүй тусламж дээрээ нэмж 300 сая иен (3 сая америк доллар орчим)-ий яаралтай буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэснээ мэдэгджээ.

2. Монгол улстай эдийн засгийн хамтын ажиллагааг илүү үр өгөөж, ашигтай хөгжүүлэхийн тулд ирэх оноос Монголд үзүүлэх тусламжийн тусгай хөтөлбөр боловсруулахын зэрэгцээ Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлэх бодолтой байгаагаа мэдэгджээ. Мөн Монгол улсад Японы хөгжлийн албан ёсны тусламж олгох тусгай хөтөлбөр боловсруулж, IV цахилгаан станцыг шинэчлэх 6.1 тэрбум иений зээл олгохоор болжээ. Ерөнхий сайд Ё.Мори: "Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хоёр шаттай зээл олгоход танай банк, санхүүгийн байгууллага хүлээн авах чадвартай эсэх, мөн өгсөн зээл эргэж төлөгдөх боломжийг судлах хэрэгтэй байна" гэж дурьджээ.

3. Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулж байгаа ба үүнийгээ хэрэгжүүлэх

4. Боловсролын солилцоог нэмэгдүүлж, 20 орчим оюутныг Японы зардлаар нэмж сургах, хувиараа суралцаж байгаа оюутны хөнгөлөлтийн асуудлыг мөн судлах зэрэг "Монголын хөгжилд Япон улс ямагт идэвхтэй дэмжлэг үзүүлэх болно" гэж Ерөнхий сайд Ё.Мори мэдэгджээ.

Ерөнхий сайд нар хоёр талын хүчин чармайлтаар хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Хэлэлцээр байгуулагдсанд баяр хүргээд, энэхүү Хэлэлцээр нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр болно гэдгийг санал нэгтэй тэмдэглэжээ. Мөн хоёр орны худалдааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх үүднээс 2001 оны 10-р сард Японд “Монголын барааны үзэсгэлэн”-г зохион байгуулахаар тохиролцжээ. НҮБ өөрийн үүрэг зорилтыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд чадавхиа бэхжүүлэх нь чухал гэдгийг хоёр тал санал нэгтэй тэмдэглэжээ. Ерөнхий сайд нар Зүүн хойт Азид яриа хэлэлцээг өргөтгөх, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр нааштай өөрчлөлтүүд гарч байгаад баяр хүргээд, тус бүс нутгийн улс төр, аюулгүй байдлын асуудлаархи яриа хэлэлцээг урагшлуулах нь чухал ач холбогдолтой гэдэгт санал нэгтэй байв.

Түүнчлэн, Монгол улсын Үйлдвэр худалдааны сайд Ч.Ганзориг, Япон улсын Гадаад хэргийн сайд Е.Кооно нар “Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай хэлэлцээр”-т, Монгол улсын Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Япон улсын Гадаад хэргийн сайд Е.Кооно нар “IV цахилгаан станцыг шинэчлэх хөнгөлөлттэй зээл олгох тухай”, “МУИС-ийн хэвлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх тухай” ноотуудад гарын үсэг зуржээ. МУИС-ийн хэвлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх буцалтгүй тусламж нь 300 мянга орчим америк доллар юм.

Ерөнхий сайд Н.Энхбаяр Японы либерал ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Кога, Японы Социал демократ намын дарга хатагтай Т.Дойт нартай уулзаж, МАХН-ын 80 жилийн ой, 23 дугаар их хуралд тус тус намуудын удирдагчийг урьж, намын орон нутгийн болон намын дэргэдэх залуучуудын байгууллага, судалгааны байгууллагуудын хооронд холбоо тогтоож хамтран ажиллах, Зүүн хойт Азийн энх тайван, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцжээ. Мөн Ерөнхий сайд Н.Энхбаяр Японы Кейданрен (эдийн засгийн байгууллагуудын холбоо) дээр бизнес эрхлэгчидтэй уулзсан нь бас нэг чухал үйл явдал болжээ. Тэрээр Монгол улс томоохон аж ахуйн нэгжүүдээ ойрын үед хувьчилахыг мэдэгдэж, энэ хөрөнгө оруулалтыг сонирхсон Японы пүүс, компаниудад энэхүү хувьчлалын үүд хаалга нээлттэй гэдгийг дурьджээ.

Ерөнхий сайд Н.Энхбаяр Японы телевизийн “NHK” корпорацид зочилж тус телевиз Монгол орныг япончуудад танилцуулахад ихийг хийсэнд талархаад “Монголын эзэнт гүрэн” баримтат кино зэрэг олон бүтээл өвөрмөц санаа агуулсан байдгийг

онцлон тэмдэглэжээ. Цаашдаа Монгол орны байгаль, түүх соёлыг тусгасан олон бүтээлийг Монголын уран бүтээлчидтэй хамтран туурвих, мэргэжилтнүүд болон программ солилцоогоо өргөжүүлэх талаар ихийг хийхийг уриалжээ. “NHK” корпорацийн ерөнхийлөгч К.Эбисава Монголд нисдэг тэрэгний осолд орж амь эрсэдсэн нөхдийнхөө ажлыг үргэлжлүүлж уран бүтээлчдийн баг илгээж нэвтрүүлэг бэлтгэж дамжуулахаа мэдэгджээ. Ерөнхий сайд Н.Энхбаяр нисдэг тэрэгний ослоор амь үрэгдсэн тус телевизийн сурвалжлагч Такахиро Като, Минару Масаки нарын дурсгалд зориулж “NHK” телевизийн хамт олон болон амь үрэгдэгсдйн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд Монголын ард түмэн, Монгол улсын Засгийн газрын өмнөөс эмгэнэл илэрхийлж үг хэлжээ. Түүнчлэн, Ерөнхий сайд Н.Энхбаяр гэргийн хамт Японы Анагаах ухааны дээд сургуулийн дэргэдэх түргэн тусламжийн төвд нисдэг тэрэгний ослын улмаас түлэгдэж гэмтэн эмчлүүлж байгаа монгол иргэдийг эргэжээ.

Ерөнхий сайд Н.Энхбаяр айлчлалын явцад Японы “Емиури” сонинд Засгийн газрын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого үйл ажиллагаа, нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, том аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын асуудлаар ярилцлага өгчээ. Мөн Японы сумо бөхийн холбоонд зочилж, Монголтой хамтран ажилладаг томоохон пүүс, компани, бизнесийн байгууллагын, жишээ нь “Иточу”, “Сумитомо”, “Жайка”, Японы гадаад худалдааг дэмжих Жетро байгууллагын удирдлагуудтай уулзжээ. Монгол улсын Засгийн газрын холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох, семинар явуулах, үзэсгэлэн зохион байгуулах, хувийн хэвшлийнхнийг холбож, дэмжлэг үзүүлэх зэргээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсний үрээр хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа өргөжиж байгааг онцлон тэмдэглээд 2002 онд Японы хөгжлийн төвийг Улаанбаатарт байгуулах, Монголд үйл ажиллагааны хүрээгээ өргөжүүлэх, Японы олон мэргэжилтэн, сайн дурынхныг Монголд ажиллуулах, XXI зууны хөдөөгийн хөгжлийн загвар болгон Монгол улсын алслагдсан аль нэг аймгийг сонгон авч хөгжлийн иж бүрэн судалгаа хийх, зэсийн баяжмал импортлох, алт олборлох, тээврийн салбарын шинэчлэлт зэрэг нэлээд асуудлаар хамтран ажиллахаар тохиролцжээ.

Ерөнхий сайд Н.Энхбаяр Японы JBIC (Олон улсын хамтын ажиллагааны банк)-ны ерөнхийлөгч Х.Ясудатай уулзаж, ерөнхийлөгч Х.Ясуда Монгол оронд олгосон бараг бүх зээл тусламжийг хэрэгжүүлсэн туршлагадаа тулгуурлан цаашид бүх талаар хамтран ажиллахаа илэрхийлжээ.

Ерөнхий сайд Н.Энхбаяр Сока Гаккай байгууллагын хүндэт

дарга Д.Икэдад бараалхаж Сока их сургуулийн хүндэт доктор цол хүртэж, ерөнхий сайдын гэргий О.Цолмон Токиогийн гадаадын сэтгүүлчдийн клубын хүндэт гишүүн болжээ. Хатан хаан Мичико Ерөнхий сайдын гэргий О.Цолмонтой Японы аж амьдрал, соёл, зан заншлын талаар ярилцсан байна. Хатан хаан “Би олон хүнтэй уулзаж явсан. Японы түүх соёлыг ийм сайн мэддэг хүнтэй урьд нь таарч байсангүй” гэж түүнд хэлж уулзалтын дараа Хааны ордны захирагч элчин сайд С.Хүрэлбаатарт хандан Ерөнхий сайдын гэргийг үнэлсэн Хатан хааны халуун сэтгэлийн үгийг дамжуулж утасджээ. Мөн Хатан хаан өөрийнхөө бичсэн “Миний багадаа уншиж байсан номууд” номыг хатагтай О.Цолмонд дамжуулж өгөхийг элчин сайд С.Хүрэлбаатараас хүссэн тухай уламжилжээ. Засгийн газрын тэргүүн нарын гадаадад хийж буй айлчлалын явцад гэргий нарын үүрэг, хариуцлага мөн их ач холбогдолтой байдаг юм. Япон улсын Эзэн Хааны Хатан хаан манай Ерөнхий сайдын гэргийн боловсрол, мэдлэгийг үнэлсэн явдалд монголчууд бид бахархаж байлаа. Мөн ерөнхий сайд Н.Энхбаяр Гифу мужид зочилж, тус мужийн хүндэт иргэн болжээ. Гифу мужийн Монголтой хамтран ажилладаг найрамдлын байгууллагууд хүлээн авалт зохион байгуулж, түүнд 700 гаруй хүн оролцож найрамдлын томоохон баяр болжээ. Энэ үед Монголд олзонд байсан япон өвгөн ерөнхий сайдад хандан “Танд мөргөө” хэмээн монголоор хэлээд, элэгсэг дотно мэндчилжээ. Ерөнхий сайд Н.Энхбаяр шинэ зуунд мэдээллийн технологийн салбарт болон аялал жуулчлалыг өргөжүүлэхэд хамтран ажиллах, цөөн тооны залуус, тэгэхдээ заавал малчны хүүхдийг Японд мэдээллийн технологийн чиглэлээр сургах, Софтопия Жапан төвтэй хамтран ажиллах тодорхой ажил өрнүүлэхийг Дэд бүтцийн яаманд үүрэг болгожээ.

Ерөнхий сайд Н.Энхбаярын Япон улсад хийсэн албан ёсны айлчлалаас харахад япон хүн монгол хүнд ямар их элгэмсэг дотно ханддагийг ажиглаж болно. Япон хүмүүс өөрсдийгөө монголоос гаралтай гэлцдэг. Юутай ч тэдэнд бидний төлөө гэх сэтгэл зүрх байгаа нь олон зүйл дээр ажиглагдаж байна. Шинэ зууны босгон дээр хүнд хэцүү шилжилтийн энэ үед хийсэн энэхүү айлчлал нь манай орны хувьд их үр дүнтэй боллоо. Японы Засгийн газар ч энэ удаагийн айлчлалд өндөр ач холбогдол өгч байлаа. Ерөнхий сайд Н.Энхбаяр энэхүү айлчлалаа “хэлбэр биш агуулга хөөцөлдсөн, үр дүнтэй айлчлал боллоо. Хоёр орны хоорондын иж бүрэн түншлэлийг шинэ агуулгаар баяжууллаа” хэмээн дүгнэжээ.

Японы Засгийн газраас гаргасан санаачилга, идэвхтэй үйл

ажиллагаа нь манай хоёр орны өнөөгийн шатны харилцаа, Монголын хөгжилд оруулж буй бодитой хувь нэмэр болж байна. Гол нь бид энэ харилцааг зөвхөн зээл, тусламж олж авах арга зам гэж ойлгох учиргүй бөгөөд хоёр талдаа харилцан ашигтай, хамтын ажиллагаа болгохыг л зорих учиртай юм. Монгол-Японы харилцааг улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбарт тал бүрээр идэвхтэй хөгжүүлэх нь Монгол орон ардчилал, зах зээлийн замаар туйлбартай урагшлах, дэлхийн бусад орон, олон улсын байгууллагуудын хүрээнд үр дүнтэй хамтран ажиллах, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааг хангаж бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм. Энэ харилцаа цаашид улам гүнзгийрэн хөгжих өөдрөг ирээдүйтэй юм.